



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/5/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	Error! Bookmark not defined.
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	Error! Bookmark not defined.
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	Error! Bookmark not defined.
2.8.3 Авлага.....	Error! Bookmark not defined.
2.8.4 Урьдчилгаа.....	Error! Bookmark not defined.
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	Error! Bookmark not defined.
2.8.6 Бараа материал	Error! Bookmark not defined.
2.8.7 Үндсэн хөрөнгө	Error! Bookmark not defined.
2.8.8 Өр төлбөр.....	Error! Bookmark not defined.
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо	Error! Bookmark not defined.
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	Error! Bookmark not defined.
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.11. Шилэн дансны мэдээлэл	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3. Менежментийн захидал.....	12
3.1 Санхүүгийн тайлан дахь авлага, өглөгтэй холбоотой асуудал	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	Error! Bookmark not defined.
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
СХС	Сум хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ДОА	Дорнод аймаг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Аудитын гэрчилгээ

		Г
ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР		Г
<small>21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг ЗДТТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203</small>		Г
Холо, 03.25 № 312		Г
танай	-ны №	-т
Аудитын гэрчилгээ		
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гурванзагал 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>		
Зөрчилгүй санал дүгнэлт		
<p>Гурванзагал сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайддын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>		
Санал дүгнэлтийн үндэслэл		
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>		
<p>Аудитаар Гурванзагал сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>		
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>		
113520254		



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ





2. Аудитын тайлан

2.1. Оршил

Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ч.Батдэлгэр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн Санхүүгийн тайлан дахь авлага, өглөгтэй холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гурванзагал сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж гүйцэтгэв.

Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гурванзагал сумын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Гурванзагал сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2019 онд Гурванзагал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Гурванзагал сумын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 1,618.9 сая төгрөгийн 2 хувь буюу 32.4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 38.7 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны гүйцэтгэлийн зардал өссөнтэй холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгайн сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллага аудитад хамрагдсан байна.



Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 6 санхүүгийн тайланд нь “Зөрчилгүй” дүгнэлт өгч, 3 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж илэрсэн асуудлыг нэгтгэсэн тайланд тусгалаа.

Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,267.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 219.8 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 3,047.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн үзүүлэлт байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Сумын Засаг дарга нь захирамж гарган Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ыг зөрчин, урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 13,224.3 мянган төгрөгийн залруулга хийлээ.

Үүнд:

- Гурванзагал сумын Эрүүл мэндийн төв: Тайлант онд малын нас дэвшилт хийгээгүй, шинэ төлийг орлого аваагүй байсанд 6,875.0 төгрөгийн залруулга хийсэн байна.
- Гурванзагал сумын Эрүүл мэндийн төв: Төсөл хөтөлбөрөөс үнэ төлбөргүй ирсэн 4 төрлийн 6,349.3 мянган төгрөгийн эмийг орлогод аваагүй байсныг санхүүгийн тайланд залруулсан байна.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 94,292.5 сая, эцсийн -үлдэгдэл 81,897.3 сая төгрөг болж, 12,395.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бүүрэлт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Касст байгаа бэлэн мөнгө</u>				
<u>Банканд байгаа бэлэн мөнгө</u>	0,1	933,2	933,1	7.5
<u>Төрийн сангийн харилцах</u>	94,292.5	80,964.1	-13,328.4	94.5
<u>Хадгаламж</u>				
<u>Дүн</u>	94,292.4	81,897.3	-12,395.2	100.0



Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 80,964.1 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 933.2 мянган төгрөг арилжааны банкны харилцах дансанд байршиж байна.

2.8.2 Авлага

Авлагын 2019 оны эхний үлдэгдэл 138,491.8 мянга, эцсийн үлдэгдэл 185,008.1 мянган төгрөг болж, 46,516.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	330.3	0.	-330.3
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	138,161.0	185,008.1	46,847.1
Зээлийн авлага			
Дүн	138,491.3	185,008.1	46,516.8

Авлагыг үлдэгдэлд шинжилгээ нийт авлагын 35.1 хувь болох 64.9 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуульд 250,0 мянган төгрөгийн он дамжсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна.
- Сум хөгжүүлэх сангийн 2011-2014 онуудад олгосон зээл, зээлийн хүү, алдангийн 64.7 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн байна. Эдгээр авлагыг төлүүлэхээр шүүхэд хандаж, шүүхийн шийдвэрийн дагуу эргэн төлөлтүүд хийгдэж байна.

2.8.3 Бараа материал

Бараа материалын 2019 оны эхний үлдэгдэл 173,747.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 195,235.5 төгрөг төгрөг болж, 21,488.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	2,665.6	4,109.0	1,443.4
Эм боох материал	1,145.2	2,297.1	1,151.9
Бичиг хэргийн материал	5,451.8	8,472.5	3,020.7
Аж ахуйн материал	79,780.8	81,821.9	2,041.1
Сэлбэг хэрэгсэл	4,940.0		-4,940.0
Түлш шатах тослох материал	1,329.7	6,039.8	4,710.1
Хүнсний материал	2,278.9	7,445.1	5,166.2
Бусад хангамж	5,358.8	6,387.8	1,029.0
Мал амьтад	70,804.1	78,662.2	7,858.1
Дүн	173,747.1	195,235.5	21,488.4

Бараа материалын үлдэгдлийн өсөлт нь: Эрүүл мэндийн төвийн малын нас дэвшлийн орлого болон бүх нэр төрлийн бараа материалын нэмэгдүүлэн худалдан авсан нь нөлөөлсөн байна.



2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн 2019 оны эхний үлдэгдэл 3,305,418.4 сая, эцсийн үлдэгдэл 3,645,003.5 сая төгрөг болж, 339,585.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	1,994,089.7	2,096,271.3	102,181.6
Автотээврийн хэрэгсэл	118,625.2	124,625.2	6,000.0
Машин тоног төхөөрөмж	263,174.4	319,858.5	56,684.1
Тавилга эд хогшил	117,227.7	134,767.7	17,540.0
Зам гүүр	300,337.1	343,201.8	42,864.7
Бусад үндсэн хөрөнгө	410,904.4	524,286.7	113,382.3
Ном	8,739.3	8,739.4	0
Программ хангамж	2,182.6	3,114.8	932.2
Бусад биет бус хөрөнгө	90,130.0	90,130.0	0
Дүн	3,305,418.4	3,645,003.5	339,585.1

Тайлант онд үндсэн хөрөнгө нь төсвөөс худалдан авсан 49.6 сая, хөрөнгө оруулалтаар хийгдсэн 289.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд хөрөнгө бууруулах ажил гүйлгээ гараагүй байна.

2.8.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5,717.9 сая, эцсийн үлдэгдэл 2,830.2 сая төгрөг болж, 2,887.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	5,685.1	2,797.8	-2,887.3	100.0
Нийт дүн	5,685.1	2,797.8	-2,887.7	100.0

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 2,797.8 мянган төгрөг нь ажлаас халагдсан төрийн албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварын өглөгтэй байна.

2.8.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,070,581.1 сая, эцсийн үлдэгдэл 3,299,656.8 сая төгрөг болж, 299,075.7 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалсан байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, Бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,367,688.1	1,367,688.1	0.0	100.0

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)



Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<u>Хуримтлагдсан үр дүн</u>	647,786.4	876,862.1	229,075.7	<u>80.1</u>
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	1,055,106.6	1,055,106.6	0.0	<u>100.0</u>
Дүн	3,070,581.1	3,299,656.8	229,075.7	94.9

Засгийн газрын оруулсан капитал данс, хөрөнгийн дахин үнэлгээний дансанд өөрчлөлт гараагүй байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гурванзагал сумын ИТХ-ын 2019 оны орон нутгийн төсөв батлах тухай 75 дугаар тогтоолд зааснаар тайлант онд 33,530.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 62,143.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 185 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	340.0	201.2	-138.8	59.1
Шууд бус орлого	16,300.0	24,714.3	8,414.3	151.6
Бууны албан татвар	1,290.0	1,080.0	-210.0	83.0
Улсын тэмдэгтийн хураамж	800.0	1,346.4	546.4	168.0
Хүүгийн орлого	10,800.0	10,789.1	-10.9	99.0
Торгуулийн орлого	3,000.0	23,496.9	20,496.9	783.0
Бусад орлого	1,000.0	516.0	-484.0	51.0
Нийт дүн	33,530.0	62,143.9	28,613.9	185.0

Орон нутгийн орлого 28,613.9 сая төгрөгөөр давсан нь торгуулийн орлого 783 хувиар давж биелсэнтэй холбоотой байна. Энэ нь сумын газар нутагт зөвшөөрөлгүйгээр олборлолт хийсэн 2 аж ахуйн нэгжид байгаль орчны байцаагч нийт 18,000.0 мянган төгрөгийн торгууль тогтоож, бүрэн төлүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 1,492,313.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,375,842.3 сая төгрөгийг урсгал зардалд, 116,471.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,477,015.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 14,298.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,000.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,452,670.5 мянган төгрөг, 2,041.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос олгосон байна. Эрүүл мэндийн төвийн магадлан



Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

итгэмжлэлийн хугацаа дууссан шалтгаанаар 12,257.0 мянган төгрөгийн санхүүжилт санхүүжилтийг авч чадаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,452,670.5 мянган төгрөг буюу 97.4 хувь байгаа нь төвлөрүүлсэн санхүүжилтийг 99.9 хувь байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 105,870.3 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,301.2 мянга, нийт 110,171.5 мянган төгрөгийн нэмэлт төсөв бүрдүүлжээ.

Үүнээс урамшууллын зардалд 1,483.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 40,600.0 мянган төгрөг, нормативт зардалд 2,460.8 мянган төгрөг, томилолтын зардалд 2,785.0 мянган, бусдаар гүйцэтгэх зардалд 7,450.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 55,392.3 мянган төгрөг нийт 110,171.51 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэлгүй ажилласан байна.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Сумдад Засаг даргын нөөц сангаас журам зөрчин зарцуулсан зөрчил нийтлэг гарч байгаа тул дараагийн аудитад анхаарах.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Гурванзагал сум нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 158 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 6,622.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн байна.

Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 06 сарын 13-ны өдрийн албан бичгээр Төрийн аудитад ирүүлсэн байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид **Гурванзагал** сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гурванзагал сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНБООУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ АВЛАГА, ӨГЛӨГТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт: Нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх явцад Ерөнхий боловсролын сургууль нь 250.0 мянган төгрөгийн он дамжсан эзэн холбогдогч тодорхойгүй авлагын үлдэгдэл, Засаг даргын тамгын газар нь нөхөн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 1,642.5 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 1,155.3 мянган төгрөг, нийт 2,797.8 төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна.

3.1.2 Эрсдэл: Төсвийн сахилга алдагдах, хөрөнгийн эргэц удаашрах.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль мөрдөн ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	406,531,066.37	462,611,051.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	94,292,597.42	81,897,322.96
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	94,292,597.42	81,897,322.96
3121	Төгрөг	94,292,597.42	81,897,322.96
31211	Төрийн сангийн харилцах	94,292,583.12	80,964,052.05
31213	Арилжааны банк дахь харилцах	14.30	933,270.91
33	АВЛАГА	138,491,370.31	185,008,198.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	330,304.31	
335	Бусад авлага	138,161,066.00	185,008,198.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	138,161,066.00	185,008,198.00
35	БАРАА МАТЕРИАЛ	137,747,098.64	195,235,530.45
351	Түүхий эд материал	3,802,863.42	6,406,143.73
35110	Тусгай зориулалттай материал	2,657,620.00	4,109,000.00
35130	Эм боох материал	1,145,243.42	2,297,143.73
354	Хангамжийн материал	99,140,097.72	110,167,199.22
35410	Бичиг хэргийн материал	5,451,861.55	8,472,561.55
35420	Аж ахуйн материал	79,780,791.66	81,821,896.66
35430	Сэлбэг хэрэгсэл	4,940,000.00	
35440	Түлш, шатах тослох материал	1,329,726.51	6,039,799.51
35460	Хүнсний материал	2,278,912.00	7,445,135.50
35470	Бусад хангамжийн материал	5,358,806.00	6,387,806.00
35600	Мал амьтад	70,804,137.50	78,662,187.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,669,768,118.50	2,840,346,036.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,669,768,118.50	2,840,346,036.63
391	Газар		
392	Биет хөрөнгө	2,579,530,310.19	2,749,437,785.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,994,089,692.62	2,096,271,330.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(118,054,656.92)	(160,790,787.19)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	118,625,151.00	124,625,151.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(47,077,194.94)	(75,009,867.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	263,174,436.24	319,858,536.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(128,984,097.45)	(156,751,225.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	117,227,724.77	134,767,724.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(48,057,960.95)	(64,068,365.49)
39209	Зам, гүүрийн байгууламж	300,337,028.90	343,201,868.90
39210	Хуримтлагдсан элэгдэл		



Гурванзагал сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		(123,019,850.37)	(145,525,977.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	410,904,464.17	524,286,745.17
39215	Хуримтлагдсан элэгдэл	(168,373,806.88)	(200,166,728.46)
39217	Ном	8,739,380.00	8,739,380.00
393	Биет бус хөрөнгө	90,237,808.31	90,908,251.62
39301	Програм хангамж	2,182,600.00	3,114,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,570,600.00)	(1,832,356.69)
39303	Бусад биет бус хөрөнгө	90,138,000.00	90,138,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(512,191.69)	(512,191.69)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,076,299,184.87</u>	<u>3,302,957,088.04</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,717,997.00</u>	<u>2,830,285.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,717,997.00	2,830,285.00
413	Өглөг	5,717,997.00	2,830,285.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,685,191.00	2,797,854.00
4136	Бусад өглөг	32,806.00	32,431.00
41361	Байгууллагад төлөх өглөг	32,806.00	32,431.00
